

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн явц	Хувь
<b>Нэг. Үйл ажиллагааны ил тод , нээлттэй байдал</b>			
1.1.	<p>Дараах зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх</p> <ul style="list-style-type: none"> <li>- байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн</li> <li>- албан хаагчийн ёс зүйн дүрэм</li> <li>- төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь</li> <li>- төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт</li> <li>- байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар</li> </ul>	<p>- Сум, хэлтэс, агентлагууд өөрийн байгууллагынхаа эрхэм, зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, нэгжүүдийн болон ажилтнуудын чиг үүрэг, байрла хаягийг тодорхойлсон мэдээллийг байгууллагын үүдний самбарт болон өрөөний хаалганы дэргэд байрлуулж байна. Байгууллагын стратеги төлөвлөгөө, бүтцэд өөрчлөлт орох бүрт дээрх материалыг тогтмол шинэчилдэг. Сум, хэлтэс, агентлагууд аймгийн ВЭБ-д үйл ажиллагааныхаа мэдээлэл, танилцуулгыг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын LCD дэлгэцээр цахим самбараар мэдээллээ ил тод болгон цацаж байна.</p> <p>-2009 оныг “ТАХ-ын сахилга, хариуцлагыг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан аймгийн төрийн байгууллагууд албан хаагчдынхаа дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг Засгийн газрын 1999 оны 58 дугаар тогтоол, 2007 оны 13 дугаар албан даалгаврын дагуу шинэчлэн боловсруулж мөрдүүлж байна. Байгууллагуудад ёс зүйн орон тооны бус зөвлөлүүд ажилладаг Энэ хүрээнд ОБХ, МХГ, ХХҮХ, Цагдаагийн хэлтэс, ШШГА, Баянжаргалан, Сайнцагаан, Говь-угтаал, Луус, Адаацаг сумдын төсвийн байгууллагууд ёс зүйн зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэн үр дүнг тооцон ажилласан байна.</p> <p>- Төрийн бүх байгууллагууд төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт, хууль тогтоомж, дүрэм, журмаар зөвшөөрөгдсөн үнэ хөлс, албан тушаалтантай харилцах утас, өрөөний дугаар, иргэдтэй уулзах цагийн хуваарь зэргийг ил тод байрлуулж хэвшиж байна. Төрийн үйлчилгээ авахтай холбоотой</p>	100

		<p>материалын жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын байранд байрлан ажилладаг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний ажлын байранд болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгал , татварын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын байранд тод томруун бичиж байрлуулсан.</p> <p>- Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж дүрэм, журам, зааварыг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд байрлуулан тогтмол шинэчилж байна.</p>	
1.2.	<p>Тухайн байгууллагас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>-“Төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” жилийн ажлын хүрээнд сум, байгууллагууд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх, хүнд суртал чирэгдэлгүй болгоход чиглэсэн нэлээд ажлуудыг зохион байгуулж байна.</p> <p>-2009 оны 3-р сараас аймгийн ЗДТГ-т “Нэг цэг”-ийн үйлчилгээг шинээр нээж наториат, иргэний бүртгэл мэдээлэл, халамжийн үйлчилгээ, банк, нийгмийн даатгал, архив, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэл, газрын албаны үйлчилгээг нэг заланд нэгтгэн иргэдэд нэг дороос үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн Эрдэнэдалай сум, Татварын хэлтэс, НДХ зэрэг байгууллагууд “Нэг цэгийн үйлчилгээ”-г ажиллуулж байгаа нь төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, үйлчилгээний чанар хуртээмжийг сайжруулахад ач холбогдолтой ажил болж байна.</p> <p>-Төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр сум байгууллагууд интернет ашиглан мэдээлэл солилцож, дотоод сүлжээ, ВЭБ хуудас, LCD ашиглан мэдээллээ иргэдэд өдөр бүр хүргэдэг болж байна.</p> <p>-“Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд шударга ёс, ил тод байдлыг хангах” аймгийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт, ярилцлагыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төсөлтэй хамтран аймагтаа зохион байгуулав. Түүнчлэн тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдал, хүнд суртал чирэгдэл, албан</p>	100

		хаагчдын үйлчилгээний талаар аймгийн ИНБ-ын Сүлжээтэй хамтран ТББ-аар иргэдээс санал, асуулга авч нэгтгэн иргэдээс гарсан санал, шүүмжлэл, хүсэлтийг “Шударга ёс, ил тод байдлыг хангах аймгийн” төлөвлөгөөнд тусган төлөвлөгөөний төслийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдэд танилцуулан санал авч бодлогын 6 зорилт бүхий 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Уг төлөвлөгөөг ЗГХЭГ, АТГ-т тус тус хүргүүлж одоо сум, байгууллагын түвшинд төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих нэгжийг байгуулан ажиллаж байна.	
1.3.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй, өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх талаар бүх шатанд анхаарлаа хандуулан ажиллаж байгаа. Энэ талаар ямар нэг гомдол гараагүй байна</li> <li>- Аймгийн ВЭБ сайтад бүх сум, хэлтэс агентлагуудын тухай мэдээллийг шинэчлэн байршуулж иргэдэд нээлттэй болгосон.</li> <li>- Засгийн газрын ВЭБ сайтад аймгийн сарын ажлын мэдээллийг сар бүр байршуулж иргэдийг аймгийн ажлын тухай мэдээлэл авах боломжоор хангасан</li> <li>- Иргэдэд сум байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг төв орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй тогтмол өгч байна</li> <li>- Шинээр гарсан хууль тогтоомж, сум байгууллагын сар, улирал, долоо хоногийн мэдээллийг мэдээллийн самбар, LCD-ээр цацаж мэдээллээ түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх арга хэмжээ авч байна.</li> <li>- Сум, байгууллагууд “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”-өөрөө үйл ажиллагааныхаа тухай иргэдэд тогтмол ил тод мэдээлж , санал хүсэлтийг сонсож байна.</li> </ul>	100
1.4.	Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээлгийн танхимд иргэд, үйлчлүүлэгчдэд зориулсан LCD зурагт байрлуулан түүгээр дамжуулан хууль эрх зүйн болоод аймгийн ИТХ, Засаг даргаас гаргаж буй шийдвэрүүдийг танилцуулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд бусад төрийн байгууллагуудыг ч энэ чиглэлээр ажил зохион байгуулах чиглэл өгч ажиллаж байна.	90
1.5	Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж	“Төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг	100

	<p>мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба ТББ, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх</p>	<p>дээшлүүлэх” жилийн ажлын хүрээнд иргэдийн болон ТББ-ын санал, дүгнэлтийг аливаа шийдвэрт тусгах, үйл ажиллагаагаа төлөвлөхдөө тусгах асуудлыг тусгай бүлэг болгож үйл ажиллагааных нь шалгуур үзүүлэлт болгон улирал бүр тооцож ажилласан.</p> <p>Шийдвэр гаргах түвшинд иргэд, иргэний нийгмийн оролцоог хангахад чиглүүлэн аймгийн ТББ-уудын сүлжээтэй хамтран ажиллаж байна. Мөн “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”, “Нээлттэй хаалганы өдөр”-ийг жилийн эхэнд баталсан графикийн дагуу зохион байгуулж иргэдээс тухайн байгууллага, сум, аймгийн түвшинд ямар ажил, үйлчилгээг санаачлан хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хэрхэн сайжруулах талаар санал асуулга, үнэлгээ авч, түүнийг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөө, тухайн сум, байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Түүнчлэн ТББ-ын төлөөллийг аймгийн ЗДЗ-ийн бүрэлдэхүүнд оруулж ИНБ-уудын сүлжээг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн.</p>	
1.6.	<p>Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Сум байгууллага бүрт санал хүсэлтийн хайрцаг, нээлттэй утас ажиллуулж иргэдээс гарч байгаа санал хүсэлт, түүний мөрөөр авсан арга хэмжээний талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон иргэдийн цуглааны үеэр тогтмол мэдээлж хэвшсэн.</p> <p>Нээлттэй хаалганы өдөр болон нээлттэй мэдээллийн өдрөөр хайрцаг аялуулан хэрэглэгчийн үнэлгээ авч, иргэдээс гарсан бодитой саналуудыг байгууллагынхаа төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж хэвшсэн.Төрийн алба, үйлчилгээний талаар нийт сумдын иргэдийн 5 хүртэл хувийг хамруулан адсан санал асуулгын үеэр иргэдээс аймаг, сум орон нутагтай холбоотой саналуудыг нэгтгэн аймаг,сум, байгууллын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.</p>	100
1.7.	<p>Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх</p>	<p>Иргэдийн өргөдөл гомдыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгдөг асуудал бүх шатанд хэвшсэн. СӨГ-ын мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох газруудад хүргүүлж байна.</p> <p>Аймаг сумын түвшинд иргэдийн өргөдөл гомдлыг өдөр бүр</p>	100

		цахимаар бүртгэн хяналтын карт хөтлөн хүлээн авч хариуг заасан хугацаанд нь өгч хэвшсэн.Төрийн байгууллага бүр үйл ажиллагааныхаа жил улирлын төлөвлөгөөнд “Иргэдээс ирүүлсэн СӨГ-ыг шийдвэрлүүлэн ажиллах талаар” тусгай бүлэг болгон тусгаж, хэрэгжилтийг тооцдог. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан санал, өргөдөл, гомдлыг амаар, бичгээр, утсаар, И-мэйлээр шуурхай хүлээн авах байдлыг хангаж ажиллаж байна. 2009 онд аймгийн хэмжээгээр нийт 16676 захидал, үүнээс амаар 4413, бичгээр 11908, утсаар 2, хурал цуглаанаар 353-ыг хүлээн авч байна. Санал 2261, өргөдөл 14163, гомдол 252 байна. Шийдвэрлэлт 100% .	
	Дундаж хувь, оноо		98.5/4.93
<b>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</b>			
2.1	Хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх	Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсронгуй болгох талаар оны эхэнд сум, байгууллагад мэдэгдэж сул орон тоонд хүн авч ажиллуулахад баримтлах журам, зааварыг сургалт, семинараар удаа дараа танилцуулж, холбогдох зөвлөмжийг заавар журмын хамт хүргүүлж ажиллаж байна. Дээрх зөвлөмжийн мөрөөр 2009 оны 6-р сард сум байгууллагаар явж үзлэг шалгалт зохион байгуулж газар дээр нь зөвлөгөө өгч ажиллалаа.	90
2.2.	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх	Удирдлагын академийн сургалтыг төлөвлөгөөнд тулгуурлан аймгийн 2009 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Удирдлагын академийн элсэлтийн шалгалтыг орон нутагтаа зохион байгуулав. Мөн төрийн жинхэнэ албаны сул орон тооны ажлын байрны захиалгыг сум хэлтэс, агентлагуудаас 2 удаа авч нэгтгэн ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-ийн ВЭБ сайтад ил тод байрлуулан төрийн албаны мэргэжлийн шалгалтыг орон нутагтаа зохион байгуулж тэнцсэн иргэдийг дарааллаар нь ажилд томилуулах арга хэмжээ авсан. Сумдаас ирүүлсэн хүсэлтийн дагуу удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг УИХ-ын 20-р тогтоолоор баталсан журмын дагуу зохион байгуулж байна. Энэ онд гарсаар Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын ЗДТГ-ын, Гурвансайхан, Дэлгэрцогт, Баянжаргалан, Цагаандэлгэр сумдын ИХТ-ийн нарийн бичгийн	100

		даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулж, ТАСЗ-ийн дүгнэлтээр тэнцсэн иргэдийг албан тушаалд нь томилуулан ажиллаж байна.	
2.3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх	Сум, байгууллагын түвшинд хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, хамгийн гол нь ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах, төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах, хууль тогтоомжийн шаардлага хангасан иргэнийг ажилд авах зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьж, Төрийн албаны салбар зөвлөлд албан хаагчдаас ирүүлсэн санал, шүүмжлэл, өргөдөлд үндэслэж байна. “Төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” жилийн ажлын хүрээнд зохион байгуулсан төрийн албан хаагчдын аймгийн зөвлөгөөнд Монгол Улсын Төрийн албаны Зөлөлийн даргыг урилгаар оролцуулж аймгийн төрийн албан хаагчдын төлөөлөлтэй уулзуулж тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.	90
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх	“Нээлттэй хаалганы болон мэдээллийн өдөр”-үүдийг сум байгууллагын хэмжээнд графикайн дагуу тогтмол зохион байгуулж иргэдээр байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдал, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид үнэлгээ өгүүлэх, тэдний санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах, өөрсдийн үйл ажиллагааг нээлттэй ил тод болгож сурталчлах арга хэмжээ тогтмол авч ажиллаж байна. Төрийн алба, үйлчилгээний талаар иргэдээс жил бүр санал асуулга явуулж дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн ХШҮ-ний тайлангийн хавсралтаар Засгийн газарт хүргэн мэдээлдэг. Сум байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний дүн, иргэдээс гарч буй саналыг нэгтгэн ард иргэдэд ил тод танилцуулж, аймаг орон нутагтай холбоотой ажил хэрэгч саналуудыг аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.	100
2.5.	Сул орон тооны зарыг олон нийтийн хэрэгслээр нээлттэй зарласан байх	Төрийн жинхэнэ албаны сул орон тооны ажлын байрны захиалгыг сум хэлтэс, агентлагуудаас 2 удаа авч нэгтгэн ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-ийн ВЭБ сайтад ил тод байрлуулан төрийн албаны мэргэжлийн шалгалтыг орон нутагтаа зохион байгуулж	100

		тэнцсэн иргэдийг дарааллаар нь ажилд томилуулах арга хэмжээ авсан. Энэ онд төрийн албаны мэргэшлийн шалгалтыг багийн Засаг дарга нарынхыг оролцуулан нийт 3 удаа зохион байгуулж явуулсан. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтуудад нийт 156 иргэн тэнцэж, төрийн албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн. Үүнээс одоогийн байдлаар 69 иргэн нь тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна.	
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өгөх үнэлгээг шударга болгох чиглэлээр өөрсдийнх нь саналыг тусган байгууллагын дотоод журамд жил бүр өөрчлөлт оруулан батлуулж ажиллаж байгаа бөгөөд 2009 онд дэвшүүлсэн зорилтууд, “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага манлайлал” аймгийн зөвлөгөөнөөс гарсан уриалга, зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор гарсан аймгийн Засаг даргын О1 тоот албан даалгаварыг төрийн албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт болгон хэрэгжүүлж байна. Дээрх уриалга, зөвлөмж нь төрийн үйлчилгээний хүнд суртал, шударга бус байдал, үйлчилгээний соёл зэрэг олон асуудлыг тусгасан байгаа нь илүү шударга байдлыг хангах нөхцлийг бүрдүүлж байна.	100
	Дундаж хувь. оноо		96.6/4.83
<b>Гурав.Төсөв санхүүгийн ил тод байдал</b>			
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсвийг дунд хугацаагаар төлөвлөн аймгийн ИТХ-аар батлуулан төсөв болон тодотгосон төсвийн сарчилсан хуваарийг санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан хийж байна.	100
3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх	Байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийн гүйцэтгэлийг байгууллагын мэдээлийн самбарт байрлуулан олон нийт, байгууллага иргэд мэдээлэл чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүллээ. Цаашид төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн талаарх мэдээллийг хүсэлт гаргасан ИНБ, иргэдэд ил тод, нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлж байна.	90
3.3.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас бүтэн	Аймаг сумдын ИТХ, Засаг дарга нарт Төсвийн гүйцэтгэлийн	100

	жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх	биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан мөн ОНТ-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийг мэдээллээр ханган, төсвийн ил тод байдлыг олон нийтэд мэдээлэх үүднээс сар бүр төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг мэдээлийн самбарт байрлуулан олон нийтэд ил тод мэдээлж байна.	
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн Аудитын мэдээллийг аймгийн ИТХ-аар нээлттэй хэлэлцүүлж, зөвлөмж дүгнэлт өгдөг бөгөөд дээрх мэдээллийг байгууллагууд мэдээллийн самбартаа бүрэн эхээр нь байрлуулан мэдээлэхийн зэрэгцээ тэмдэглэлээр нийт сум байгууллагад хүргүүлж зохих үүрэг даалгавар өгч ажилладаг.	100
3.5	Тухай жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх	Төсөвт өөрчлөлт оруулсан тухай ИТХ-ын шийдвэрүүдийг шат шатны байгууллагуудад хурал, цуглаан хэлбэрээр олон нийтийн бүхий л арга хэмжээн дээр мэдэгдэхийн зэрэгцээ байгууллагууд өөрсдийн мэдээллийн самбараар дамжуулан хүргэж байна.	100
3.6	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчдээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх	Төсвийн ерөнхий менежерүүд аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас зохих төлбөр хураамж авах, шат дамжлагатай үйлчилгээний талаарх мэдээлэл, холбогдох шийдвэрүүдийг олон түмэнд ил тод хэлбэрээр байгууллага дээрээ байрлуулах талаар нэгдсэн зөвлөмж, чиглэл өгч ажилладаг бөгөөд энэ чиглэлээр аймгийн хэмжээнд байгууллагууд нэлээд нээлттэй ажилладаг болсон.	90
3.7	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгохоор аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар “ Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ыг боловсруулан хэлэлцүүлж 2009.03.10-ны 97 тоот захирамжаар батлуулж бүх сумд, төсөвт байгууллагуудын менежерүүдэд хүргүүлэн мөрдүүлж ажиллаж байна.	100
	Дундаж оноо. хувь		97.1/4.85
<b>Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал</b>			
4.1	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар “ Төсөвт байгууллагуудад бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, гүйцэтгэгч сонгон шалгаруулахад баримтлах журам” –ыг боловсруулан хэлэлцүүлж Засаг	100



	талаар олон нийтэд мэдээлсэн байх	даргын 2009.03.09-ны 92 тоот захирамжаар батлуулж бүх сумд, төсөвт байгууллагуудын менежрүүдэд хүргүүлэн мөрдүүлж, хэрэгжилтэд нь холбогдох салбарын байгууллагууд хяналт тавьж ажиллаж байна.	
4.2	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хууль заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудаст байршуулан, тогтмол шинэчилж байх	Үнэлгээний хороод тендерийн бичиг баримтыг зохих хууль тогтоомж, журам зааврын дагуу боловсруулж тендерийн урилгыг цахим хуудаст байршуулан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, тогтмол шинэчилж хэвшсэн.	100
4.3	Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/ -ийг оролцуулсан байх	Үнэлгээний хороонд тухайн салбарын 1-ээс доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулж ажиллалаа.	90
4.4	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх	Тендер шалгаруулалт явуулахдаа оролцогчдыг байлцуулж хэвшсэн бөгөөд энэ нь шалгаруулалт явуулсан үндэслэлийг оролцогчид бүрэн ойлгох нөхцлийг бүрдүүлдэг. Түүнчлэн оролцогчдод шалгаруулалтын дүнгийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг үйлдэж танилцуулдаг. Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлж байна.	100
4.5	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	Тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг үнэлгээний хорооны тэмдэглэлд тодорхой дурьдаж оролцогчдод мэдээлж танилцуулдаг.	70
4.6	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх	Худалдан авалтын тайланг жилийн эцэст нэгтгэн сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, жил бүр аймгийн ИТХ-д танилцуулдаг. Тус аймгийн хувьд аймгийн Вебийг илүү амьд байнгын мэдээлэлтэй байх нөхцлийг бүрдүүлэхээр хөрөнгийн асуудал шийдэгдэж одоо хэрэгжих шатандаа явж байна. Ингэснээр байгууллагынхаа Веб хуудсаар дамжуулан мэдээллийг илүү нээлттэй болгох боломж бүрдэх юм.	100

4.7	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар хийгдсэн тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ирсэн бөгөөд 2009 онд энэ чиглэлээр зөрчил дутагдал илрээгүй байна.	100
4.8	Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх	Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр Сангийн яамны ХААБЗГ-аас зохион байгуулсан сургагч багшийн сургалтанд 1 хүн, ХАА-ны чиглэлээр мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтанд 4 хүнийг хамруулж сертификат олгогдсон. Мөн Сангийн яамны ХААБЗГ-тай хамтран аймгийн төвийн төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд сургалт зохион байгуулж, нийт 65 хүн, сумдын төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд сургагч багш сургалт зохион байгуулж, нийт 60 хүнийг сургалтанд хамруулан, сертификат олгосон.	100
4.9	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан , түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх	2008 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт тайланг аймгийн ИТХ-аар оруулан хэлэлцүүлж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбарт ил тод байлуулж олон нийтийг танилцах боломж бүрдүүлэн ажиллаж байна.	100
4.10	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 2009 онд ирээгүй бөгөөд 2008 онд нэг өргөдөл ирж өргөдөлийг судлах, шийдвэрлэх явцад тухайн компаний буруутай үйлдэл болох нь тогтоогдож уг компани хүлээн зөвшөөрч өргөдөлөө буцаан татсан байна. Дээрх өргөдөлийн шийдвэрлэлтийг бусад СӨГ-ын нэгэн адил хариуг хугацаанд мэдэгдэв.	100
	Дундаж оноо. хувь		96.0/4.8/
	Ерөнхий үнэлгээ		4.85

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**